

## **Аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын үүсэл хөгжил, танилцуулга**

Манай аймаг анх 1942 онд байгуулагдаж жилдээ 562.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг барилгын , оёдлын 2 артель бүхий үйлдвэр хоршооллын артель, цөцгийн тос боловсруулах завод 4, талхны цех зэрэг үйлдвэр үйлчилгээний салбар бүхий жилдээ 700 орчим мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүнсний үйлдвэр ажиллуулж байжээ.

2004-2007 онд манай аймгийн хувьд Цайрт минериал, Баянцогт мөнхийн гал 2009 онд Баян-Эрч, Эрвэн хүдэр гэх зэрэг тоомоохон уул уурхайн компаниуд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллагчид, зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг.

Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан, тооллого, судалгааны материал нь болдог.

2005 оноос эхлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр тооцож байна.

### **Аж үйлдвэрийн салбарын ангилал:**

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал ( IV хувилбар )-ыг 2009 оноос эхлэн мөрдөж байна.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхлэдэг нэгжийг тэдгээрийн дотор мэдэгдэхүйц өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь үндсэн салбарт оруулдаг

### **Аж ахуйн нэгж байгууллагын тоо**


2010 оны **бизнес регистрийн санд** бүртгэлтэй 463 ААН байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа 421, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 42 ААНБ байна. Үйл ажиллагаа явуулахгүй байгаа ААНБ-ын шалтгааныг авч үзвэл эхлээгүй 2, бүрэн зогссон 6, түр зогсоосон 31 байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 45.6 хувийг ХХК, 29 хувийг ТБ, 7.8 хувийг ЗБН, 6.4 хувийг ББН, 4.7 хувийг хоршоо, 3.8

хувийг ТББ, 1.6 хувийг ОНӨҮГ, 0.4 хувийг ХК, ТӨҮГ тус тус эзлэж байна. Өмчийн хэлбэрээр авч үзвэл 68.9 хувь буюу 290 нь хувийн, 29.4 хувь буюу 124 нь төрийн өмчит, 1.7 хувь буюу 7 нь орон нутгийн өмчтэй байна. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоог эдийн засгийн салбарын ангилалаар хүснэгтээр харуулбал:

**ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар**

Үйлчилгээ	Ажаа	Ооо оодооэ i eai ðei ö æe зееэүүд	Ái ei aṅðóóeáð ææ зееэүүд	Óæöeæái, áóeai ú зееэүүдөйе, óñai óai æai æ	Аадееа	Áó i eé áa ææææyi óóáæááá, áyð áðóeí ááðáá i ú çáñúàðeáð зее-еэүү	Çi -eá áóóáæ çí i æeéi æçað	Öyýáð, ááóóeáóú i æe áðóe, öi eái i
2006	355	2	7	5	6	87	7	9
2007	394	2	7	3	8	102	12	6
2008	385	4	8	5	8	110	20	9
2009	424	4	8	5	11	135	24	10
2010	421	3	7	3	12	154	24	8

Үйлчилгээ	Ṃai öççæeí æçeéyú öeóð зее ааеэааа	çe ö æe ö ö i ç öççyñ, æeçí aṅeéi çeé ааеэааа	Ö ðeéi óæðeæeáá, ááðeai óai ææeáð.æeái æóð i i eéá eéi ááðæeú i	Ái ei aṅðí eú i çeé ааеэааа	Ýðççe i yí a, i eéá eéi óæeai æeéi çeé ааеэааа	í eéyi, áeá öççá ççççyö áóñáá çeé ааеэааа
2006	29	9	45	33	59	44



ХАА-н, Барилгын салбарт 2.8 хувь, Уул уурхай, олборлох, Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжид 0.7 хувь, Боловсруулах үйлдвэрт 1.7 хувь, Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарт

36.6 хувь, Зочид буудал зоогийн газарт 5.7 хувь, Тээвэр агуулахын аж ахуй, холбоонд 1.9 хувь, Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаанд 2.6 хувь, үл хөдлөх хөрөнгө түрээс бизнесийн үйл ажиллагаанд 2.4 хувь, Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалд 11.9 хувь, боловсролын салбарт 8.8, Эрүүл мэндийн салбарт 12.8 хувь, Нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд 8.5 хувь нь нь тус тус үйл ажиллагаа явуулж байна.

**Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд  
аж үйлдвэрийн эзлэх байр суурь  
/ салбарын ангиллаар /**

/сая.төг/

Аж үйлдвэрийн салбар	2006	2007	2008	2009	2010
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	31.0	35.8	37.1	34.7	52.6
Аж үйлдвэр, барилга	93.7	104.0	56.8	63.3	56.2
Үйлчилгээ	8.0	10.7	22.7	16.1	24.4
<b>Дүн</b>	<b>132.7</b>	<b>150.5</b>	<b>116.6</b>	<b>114.0</b>	<b>133.1</b>

2010 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 133.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. ДНБ нь 2007 оныхоос 12.9 хувиар буурч, 2008 оныхоос 12.4 хувиар, 2009 оныхоос 15.9 хувиар тус тус өссөн тооцоо гарч байна.




Нэг хүнд ногдох ДНБ нь 2006 онд 2.4 сая, 2007 онд 2.7 сая, 2008 онд 2.1 сая, 2009 онд 2 сая, 2010 онд 2.4 сая төгрөг тус тус ногдож байна.

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн**  
**/ 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг /**

Аж үйлдвэрийн салбар	2006	2007	2008	2009	2010	2010/ 2009 %
Уул уурхай, олборлох	11508.9	28669.5	30544.9	29635.1	24188.4	81.6
Боловсруулах аж үйлдвэр	79.7	68	82.2	154.2	276.7	179.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	604.4	2599.6	3252.5	3899.3	3997.6	102.5
Ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	194.9	307.9	230.8	215.4	213	98.9
<b>ДҮН</b>	<b>12391.0</b>	<b>31675.9</b>	<b>34146.2</b>	<b>33904.0</b>	<b>28675.7</b>	<b>84.6</b>

2005 оны зэрэгцүүлэх үнээр аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь 28.7 тэрбум төгрөг болж, 2006 оноос 2.3 дахин өсч, 2009 оноос 15.4 хувиар буурсан гүйцэтгэлтэй байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 84.3 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр эзлэж байгаа хэдий ч сүүлийн 2 онуудад буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 5 жилээр графикаар харуулбал:




Аймгийн аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 104.6 тэрбум төгрөг болж, 2006 оныхоос 2 тэрбум төгрөгөөр буурч, 2009 оныхоос 2.7 хувиар буюу 2.7 тэрбумаар өссөн үзүүлэлттэй байна. 2006 оныхоос уул уурхайн борлуулалт 4.3 тэрбум төгрөгөөр буурсан нь гол нөлөөлж байна. Бусад салбарын борлуулалт өссөн үзүүлэлттэй байна.

БНХАУ-д 2006 онд цайрын баяжмалыг экспортолж байсан бол 2010 онд цайрын баяжмал, хүрэн нүүрс, төмрийн хүдэр, молибединий баяжмалуудыг экспортолж байна.

### Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн / оны үнээр /

Аж үйлдвэрийн салбар	2006	2007	2008	2009	2010	2009/ 2008 %
Уул уурхай, олборлох	105293.3	137962.7	72690.8	98775.1	101081.6	102.3
Боловсруулах аж үйлдвэр Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	77.4	76.6	198.4	329.5	649.8	197.2
Үүнээс: ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	1085.2	1118.7	2670.1	2837.5	2916.8	102.8
ДҮН	138.3	283.2	217.8	222.1	230.1	103.6
<b>ДҮН</b>	<b>106604.7</b>	<b>139441.2</b>	<b>75559.3</b>	<b>101942.1</b>	<b>104648.1</b>	<b>102.7</b>

Дээрхи бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2010 оны борлуулалтаар бүтцээр нь авч үзвэл:



## Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2006	2007	2008	2009	2010	2010/ 2009 %
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>							
Нүүрс	мян.тн	38.5	68.7	113.1	60.9	119.6	196.4
Цайрын баяжмал	мян.тн	110	136.3	143.6	141.3	112.5	79.6
Төмрийн хүдэр	мян.тн	-	-	-	-	10.8	-
Молибдений баяжмал	мян.тн	-	-	-	0.5	0.1	20.0
<b>Боловсруулах үйлдвэрлэл</b>							
Талх	тн	49.9	63.1	79.2	109	329.2	3*
Нарийн боов	тн	18.7	26.7	40.4	68.4	82.4	120.5
Ул боов	тн	-	-	-	-	24.4	-
Хиам	тн	-	-	-	4.2	2.8	66.7
Архи	мян.л	9.7	3.7	2	1.0	-	-
Блок	мян.ш	8.6	35	63.9	19.2	32.0	166.7
Улаан тоосго	мян.ш	-	-	-	75.9	-	-
Өнгөт тоосго	мян.ш	-	-	-	15.8	11.3	71.5
Замын хавтан	м2	250	2858.5	2000.1	1908.3	2843	149.0
Барилгын ялуу	м3	0.2	...	...	46.8	39.9	85.3
Эсгий	мян.м	...	...	0.8	6.8	2.8	41.2
Маягт	мян.х.д.х	-	-	-	22.7	-	-
Ном	мян.х.д.х	-	-	-	3.6	-	-
<b>Цахилгаан, дулаан, усан хангамж үйлдвэрлэл</b>							
Цахилгаан	мян.кв.цаг	254.5	305.1	272.5	248.1	-	-
Дулаан	мян. гкал	50.0	60.6	67.1	77.5	83.3	107.5

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2006 онтой харьцуулахад 2010 онд архинаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Харин өнгөрсөн онтой зэрэгцүүлбэл: талх, нарийн боов, ул боов, дулаан, нүүрс, блок, замын хавтангийн үйлдвэрлэлт өсч, цайрын баяжмал, молибдений баяжмал, хиам, өнгөт тоосго, барилгын ялуу, эсгийний үйлдвэрлэлт буурч, архи, цахилгааны үйлдвэрлэлт хийгдэхээ больсон байна. Энэ нь манай аймгийн 13 сум цахилгааны төвлөрсөн системд холбогдсоноос болж цахилгаан үйлдвэрлэлт зогссон.


**2.Барилга:** Бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын үйл ажиллагаа явуулж байгаа 10 ААН байгууллага байна. Аймгийн хэмжээнд 5656.3 сая.төг-ийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь өнгөрсөн оноос 3.2 дахин өсч, 2005 оныхоос 23.6 дахин буюу 5416.4 мянгаар өссөн байна. 2010 онд 14 барилга байгууламж ашиглалтанд оруулсан нь өнгөрсөн оноос 17.6 хувиар буурсан байна. Нийт ашиглалтанд орсон барилга байгууламжийг зориулалтаар нь авч үзвэл: Орон сууцны барилга 240.0 сая төг, эмнэлгийн барилга 157.8 сая, сургууль, соёлын

барилга 30.0 сая, Эрчим хүчний шугам 24.4 сая, далан, суваг, шугам сүлжээ 9.8 сая, зам талбай 12.7 сая төгрөгөөр тус тус баригджээ.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2005	2007	2008	2009	2010	2010/ 2009
Барилга угсралт их, засварын ажил	239.9	736.9	3449.6	1750.2	5656.3	323.3
Ашиглалтанд оруулсан барилга, байгууламж	7	9	13	17	14	82.4

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг сүүлийн 6 жилийн байдлаар графикаар харуулбал:



**Тухайн аймгийн нутаг дэвсгэр дээр худалдааны үйл ажиллагаа явуулах, орчин нөхцөл бололцоо.**

Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт 82.3 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг эзлэн, урд талаараа БНХАУ, баруун талаараа Дорноговь, баруун хойт талаараа Хэнтий, зүүн талаараа Дорнод аймагтай тус тус хиллэдэг.

Аймаг 2010 онд 15.5 мянган өрх, 54.9 мянган суурин хүн амтай болсон бөгөөд нийт өрхийн 49.4 хувь буюу 7.7 мянган өрх аймаг, сумын төвд амьдарч байна.

Нийт хүн амын 52.4 хувь нь хөдөө, 47.6 хувь нь аймаг сумын төвд амьдарч байгаа ба 67 хувь нь 15-59 насны хөдөлмөрийн насны хүн байна.

### 3. Худалдааны салбарын үүсэл хөгжил ба өнөөгийн байдал

Худалдааны салбарт 154 ААНБайгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус салбарт 442 орчим хүн ажиллаж байгаа нь аймгийн нийт ажиллагсдын 8.2 хувийг эзэлж байна.


Худалдааны графикт мэдээнд хамрагдаж үйл ажиллагаа явуулж байгаа 22 Аж ахуйн нэгж байгууллагад 95 хүн ажиллаж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс ажиллагсдын тоо 69.6 хувь буюу 41 хүнээр өссөн байна.

Нийт борлуулалтын орлого 2830.9 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 56.2 хувиар буюу 1018.2 сая төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй байна. Нийт орлогыг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл: шатахуун борлуулалтын орлого 3.9 хувь, эм гоо сайхны бараа 5.2 хувь бусад төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 90.9 хувийг эзэлж байна.

Худалдааны салбарын гүйцэтгэл сонгогдсон /ААНБ/-аар

Үзүүлэлт	Нийт орлого /сая.төг/				Ажиллагсдын тоо				Мэдээлэлд хамрагдсан байгууллага			
	2007	2008	2009	2010	2007	2008	2009	2010	2007	2008	2009	2010
Шатахууны жижиглэн худалдаа	118.3	115.8	39.0	111.6	8	7	10	15	2	2	1	2
Эм, гоо сайхны барааны жижиглэн худалдаа	92.8	130.9	79.4	146.9	12	13	17	8	2	2	1	1
Бусад төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	1 550.5	1 967.0	1812.7	2830.9	100	90	29	72	40	40	19	19

Худалдааны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



**4. Холбооны үйлчилгээний орлого радио телефон цэгийн тоо**

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

**Нийт орлого** Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо,хөдөлгөөнт холбоо,мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.



**Үүрэн телефон хэрэглэгч** Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

**Утасгүй холбооны хэрэглэгч** Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгч .


**Интернет кафе** Олон нийтэд нэг цэгт интернет үйлчилгээ үзүүлэгч байгуулагаа аж ахуйн нэгж

2010 онд 324.1 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувь буюу 9 сая төгрөгөөр буурсан байна. Хүн амаас орох орлого нь нийт орлогын 48.3 хувийг эзэлж байна.

Холбооны салбарын үзүүлэлтүүд / оноор /

Үзүүлэлт	хэмжих нэгж	2005	2007	2008	2009	2010
Нийт орлого	сая.төг	483.9	521.9	444.8	333.1	324.1
Хүн амаас орох орлого	сая.төг	250.3	273.4	197.6	145.3	156.7
Телефон цэг	ш	1580	1527	1422	1710	931

Холбооны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Суурин телефон цэгийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 45.5 хувь буюу 779-өөр буурсан байна. Сүүлийн жилүүдэд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо эрс өсч байна.

Тус аймгийн иргэд, хөдөлмөрчид Ньютел, Скайтель, Юнитель, Жи мобайл зэрэг үүрэн телефоны хэрэглэгч болсноор холбооны орлого болон суурин телефон хэрэглэгчийн тоо буурах хандлагатай болж байна. Тээвэр холбооны салбарт аймгийн нийт ажиллагсдын 1.5 хувь нь буюу 388 хүн ажиллаж байна.

**5.Тээврийн салбарын тээсэн ачаа,зорчигчдын тоо,ачаа эргэлт,зорчигч эргэлт**

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт,тээсэн ачаа,зорчигч эргэлт,авто машины тоо,шилжүүлсэн тонн,км ажиллагсдын тоо орлого зэрэг орно

.Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд дамжуулдаг,  
**Ачаа эргэлт** Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт


**Зорчигч эргэлт** Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ  
**Шилжүүлсэн тонн км** Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффицентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

Тээвэр бүхий байгууллагууд 2010 онд 175.3 мян.тн ачаа тээвэрлэж, 22.8 мян.хүн тээвэрлэж, ачаа эргэлт 48248.2 мян.тн.км, зорчигч эргэлт 9099.2 мян.хүн.км-ийн ажил гүйцэтгэж, нийт орлого 5108 сая төгрөгт хүрлээ. Тээсэн ачаа 2005 оныхоос 8.6 дахин, 2009 оныхоос 6.9 хувиар буюу 12.9 мян.тн-оор буурч, зорчигчдийн тоо 64 хувь буюу 8.9 мян.хүнээр, 2009 оныхоос 9.2 мян.хүнээр тус тус өссөн байна. 2005 оноос тээсэн ачаа 8.6 дахин буюу 154.8 мян.тн-оор, зорчигчдийн тоо 1.6 дахин буюу 8.9 мян.хүнээр тус тус өссөн гүйцэтгэлтэй байна. Тээврийн байгууллагын тээсэн ачаа, ачаа эргэлтийн эдийн засгийн үзүүлэлт буурч байгаа нь тус аймагт Цайрын баяжмалыг гадны байгууллагаар гүйцэтгэх болсонтой холбоотой юм. Гэхдээ тээврийн зонхилох орлогыг Цайрт фрейд ХХК оруулдаг бөгөөд нийт орлогын 84 хувь буюу 4291.8 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Тээврийн салбарын гүйцэтгэл

Үзүүлэлт	хэмжих нэгж	2005	2007	2008	2009	2010	%
Тээсэн ачаа	мян.тн	20.5	194.9	149.6	188.2	175.3	93.1
Ачаа эргэлт	мян.тн.км	466.2	5 505.4	42 141.2	54 874.6	48248.2	87.9
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	13.9	25.6	22.1	13.6	22.8	167.6
Зорчигч эргэлт	мян.хүн.км	6 425.6	12 356.0	8 853.8	7 210.0	9099.2	126.2
Тээврийн орлого	сая.төг	55.8	275.9	5 922.0	6 603.8	5108	77.3

Тээврийн салбарын гол үзүүлэлт болох тээсэн ачаа, зорчигч тээвэрлэлтийг графикаар харуулбал:




Манай аймгийн хэмжээнд авто техникийн 2010 оны улсын үзлэгээр бүх төрлийн авто машин нийт 3.5 мянга болсны 52.7 хувь буюу 1.9 мянга нь суудлын авто машин, 43.6 хувь буюу 1.5 мянга нь ачааны, 3.3 хувь буюу 118 автобус, 0.4 хувь буюу 11 тусгай зориулалтын авто машин байна. Нийт авто машиныг ашиглагдсан хугацаагаар ангилж авч үзвэл: 20.9 хувь буюу 739 машин нь 10 хүртэлх жил, 79.1 хувь буюу 2790 машин нь 10-аас дээш жил ашиглагджээ. Өнгөрсөн оноос 3 хувиар авто машины тоо өсчээ.

Улсын үзлэгийн дүнтэй харьцуулбал: нийт авто машины тоо 1.4 хувийг эзэлж байна.

Авто машины тоо /төрлөөр/

Үзүүлэлт	2005	2007	2008	2009	2010	төрлөөр			
						суудлын ачааны	Ачааны	автобус	тусгай зориулалтын
Авто машины тоо	1883	2 452	2 632	3 427	3 529	1 861	1 539	118	11
Улсын дүн	131184	161 989	190 459	224 068	254 486	172 583	61 841	16 366	3 696



■ Авто машины тоо

## Дүгнэлт, санал

Манай аймгийн хувьд уул уурхайн салбарын “Цайрт минериал”, “Андын элч”, “Баян-Эрч” зэрэг томоохон компаниуд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр борлуулалт, бүтээгдэхүүний нэр төрөл, биет хэмжээ нэмэгдсэнээс гадаад дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх байр суурьд ихээхэн өөрчлөлт орсон. Гэвч 2009, 2010 оныг харьцуулахад нийт үйлдвэрлэлт буурсан байна. Энэ нь эдийн засгийн хямралаас болж үнэ бага, худалдан авах чадвар муу байсан учир урьд оны бүтээгдэхүүний үлдэгдэл их, үйлдвэрлэлт бага болсонтой холбоотой юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүнээр 2006 онд улсын хэмжээнд 2-рт орж байсан бол 2010 онд 7-р байр эзлэж байна. 2010 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2.4 сая төгрөг болж байна.

Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдэж, бизнес эрхлэж амьдрал ахуйгаа дээшлүүлж байгаа иргэдийн тоо нэмэгдэж, ард иргэдийн амьдрал дээшилж байгаа бөгөөд манай аймгийн худалдааны салбарт нөлөөлөх нэг давуу тал нь БНХАУ-тай хөрш зэргэлдээ оршиж худалдаа наймаагаа хөгжүүлж байгаа явдал юм. Тухайн аймгийн худалдааны салбарын нийт орлого жил ирэх тутам өсч байгаа нь манай хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэд, бизнес эрхлэгчдийн маань хүчин зүтгэл, мөн банкны байгууллагуудын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж олгож байгаа зээл, бөөний сүлжээний төв байгуулж төсөл хэрэгжүүлж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

2009 оноос манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг бүрдүүлж эхлээд байна.

Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа бөгөөд тээврийн ачаа болон зорчигч тээврийн орлого үйлчилгээний хэмжээ өссөн үзүүлэлтэй байна.

Холбооны салбарын хувьд түлхүү хөгжиж ирсэн нь харагдаж байна. Тус аймаг шилэн кабелийн сүлжээнд холбогдож, техник технологийн шинэчлэлт хийсэн нь олон давуу талыг харуулж байна. Гэвч холбооны салбарын эдийн засгийн үзүүлэлт жил ирэх тутам унаж байна.

Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг нь бидний хувьд ямарч мэдээлэл дүгнэлт байдаггүй нь дутагдалтай.

Хойшид үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээрхи санал:

- Шинээр худалдааны чиглэлээр бий болж байгаа ААН Байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэрийн хоёр хүн дарга, нягтлан гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, АШБ хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.
- Манай статистикийн мэдээний хугацаатай холбооны мэдээлэл таардаггүй нь мэдээний гүйцэтгэл бүрэн хамралттай орж чаддаггүй дутагдал сүүлийн жилээс гарч байна. Иймд Монголын цахилгаан холбоотой мэдээний графикаа зохицуулалт хийх
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй хотоос үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн компани байна. Энэ компанийн мэдээллийг оршин байгаа дүүргийн статистикийн хэлтсээр авахуулж авч болох эсэх.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2005, 2007, 2008, 2009, 2010 оны гүйцэтгэлээр харууллаа.

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ, тайлан

---

ДНБ-ний тооцоо улс, аймаг, он оны статистикийн эмхтгэл  
Хүн ам өрхийн бүртгэлийн сангийн үзүүлэлт зэргийг ашиглав.

**Танилцуулга бичсэн**

**Ц.Хад**